

Номын ачит багш Чой. Лувсанжав профессорныхаа дурасхалд зориулав.

**Монгол хэлний “тийн ялгал”-ын нэр томъёо,
түүний гарлын асуудалд[♥]**

Ц.Шагдарсүрэн

Үүнийг бичигч хэдэн жилийн өмнө нийтлүүлсэн “Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм” гэдэг өгүүлэлдээ монгол хэлний тийн ялгал хэмээх хэлзүйн айн талаар доор өгүүлэх санааг товч хөндөж “Монгол хэлний “тийн ялгал”-ын нэр томъёо, түүний гарлын асуудалд”-ын талаар тусхайлан бичихээ амласаны дагуу энэхүү өгүүллийг толилуулж байна¹.

Монголын уламжлалт хийгээд орчин үеийн хэлшинжлэлийн зохиол бүтээлийн зүйлийг ерөнхийд нь авч үзэхүл нэгд, эртний Энэдхэгийн Банин (Panini)-ы хэлзүйн уламжлал шууд болон Төвөдөөр дамжин орж ирсэн, хоёрт, мөнхүү тэр уламжлал өнгөрөгч XIX зуунаас Энэдхэг-Европын хэлний зүй бичдэг Герег-Романы уламжлалаар дахин хүчтэй нөлөөлсөн, үүний зэргэцээ монгол хэлийг монгол хэлний уугуул онцлогийнхи нь үүднээс авч үзэх явдал харьцангуй хожуу эхлэсэн байдал тодорхой харагддаг бөлгөө. Иймд энэ тухай яльгүй тодруулан авч үзсүгэй.

1. Уламжлалт хэлшинжлэлийн бүтээлүүд: үүнд, бидний өнөөдрийн мэдэлгийн хирээр жинхэнэ эхээрээ хараахан хүрэлцэж ирээгүй боловч бие бодтой байсан гэдэг нь хэдийнээ тодорхой болсон уламжлалт хэлшинжлэлийн зохиолууд, тухайлбал, Сажа бандида Гунгаажалцан (1188-1251), Чойжи-одсэр (XIII-XIV), Гунгаа-одсэр (XVI-

[♥] 1998 оны 1-р сарын 10-нд Сөүл хотноо болсон ЭШ-ний хуралд тавьж хэлэлцүүлсэн илтгэлийн нэмж зассан эх.

Ц. Шагдарсүрэн, Монгол хэлний “тийн ялгал”-ын нэр томъёо, түүний гарлын асуудалд (Товчлол) - International Academic Conference on Korea and Mongolia, Seoul, 1998, pp. 49 - 53. Cf. *Mongolian Studies* (The Korean Association for Mongol Studies), N. 5 (1997), Soeul, 1998, pp.247 - 257.

¹ Ц. Шагдарсүрэн, Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм, - *Mongolian Studies* (The Korean Association for Mongol Studies), N. 6 (1998), Soeul, 1999, (pp. 61-139) ... ; Эртний монгол хэлний судлал (Монголын судлалын сонгомол өгүүлэлийн эрхи, I хэлмэли: Монгол хэл бичиг, II дэвтэр), Улаанбаатар, 1999, (67 - 125) 83 -р талаас үзмүү.

XVII) нарын нэр нэгтэй “Зүрхний толт”-аас авуулаад бидний үетэй золгосон, зарим тоймтойгоос нь дурдвал, Рабжамба Данзандагвын “Зүрхний толтын тайлбар үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч огторгуйн маань хэмээх судар оршивай” болон түүнд шүтэж зохиосон Лувсанчойнхор, Дэлэгжунай нарын “Монгол үсгийн гол ёсыг тодотгогч толь”, Агваандандарын “Монгол үсгийн ёсыг сайтур номлосон Хэлний чимэг”, Лхамсүрэн захирагчийн “Монгол үсгийн ёсыг тодорхойлон гаргасан Алтан толь” зэргийг багтаан үзэж байна².

Энэ хэсэгт хамааруулсан бүтээлд Эртний Энэдхэгийн хэлшинжлэлийн уламжлалт үзэл гол төлөв Төвөдөөр дамжин нөлөөлсөн нь тодорхой харагддаг бөлгөө.

2. Орчин цагийн хэлшинжлэлийн бүтээлүүд: үүнд, Герег-Романы хэлзүйн зарчимд үндэслэсэн Энэдхэг-Европ хэлний зүйн жишигээр зохиосон бөгөөд XIX зууны эхний хагасаас судлагааны чанар төвшингийн хувьд үлэмжхэн ахисан монгол хэлний шинжлэлийн бүтээлүүд, тоймтой томоохоноос нь дурдвал, Я.Шмидт (I.J.Schmidt), А.Бобровников нарын Хэлзүй-н бүтээлүүд болон тэдгээрт дулдуйдан зохиосон гадаад, дотоодын эрдэмтдийн бичсэн монгол хэлний олон Хэлзүй-н ном бүхэлдээ багтана. Гэхдээ энэ хэсэгт хамааруулсан монгол хэлний зүйн номыг дотор нь хоёр ангилаж үзэх нь зүйд нийцэх буй заа.

2. 1. Христусын тооллоор, XIX зууны эхний хагасаас эхлээд өдгөө хүртэл нийтлэгдэн гарсан монгол хэлзүйн ном зохиолын олонхи нь монгол хэлний янз бүрийн асуудлыг Герег-Романы хэлзүйн онолыг баримтлан тайлбарласаар иржээ. Тухайлбал: үгсийг аймаглах, тэмдэг нэр хийгээд түүний зэрэг, нэр үгийн тоо, тийн ялгал, туслах үйл үг, дайвар үг гэх зэрэг олон асуудлыг дурдаж болно. Зөвхөн тооны нэрийн хүрээнд л гэхэд бутархай тооны нэр байна гэж үзсэн байх жишээтэй. Гэтэл монгол хэлнээ бутархай тоог үгзүйн аргаар бус, хэлзүйн аргаар хэрхэн илэрхийлдэг вэ? гэдгийг бутархай тооны “нэр”-тэй адилтгаж огт болохгүй, хоёр өөр зүйл бөлгөө. Нэг нь хэлбэрсудлал буюу үгзүйн, нөгөө нь өгүүлбэрзүйн судлагдахуун билээ. Бас дэс тоо, түгээл тооны “нэр”-ийг чухамдаа заримдаг байдалтай гэж хэлж болно. Тэмдэг нэрийн “харьцуулсан” болоод “давуу зэрэг” гэдэг бүхэлдээ ийм бөгөөд үгзүйн хувьд тусгай хэлбэргүй, дурдсан харьцааг өгүүлбэрзүйн аргаар илрүүлдэг билээ. Энэ мэт цаашид анхаарууштай маш олон зүйл буй.

Тэгэхдээ эхний үед, ялангуяа гадаадын эрдэмтэд монгол хэлний зүйг шинээр бичихэд ямар нэгэн хэмжүүр, загварыг баримтлахаас өөр аргагүй тул хамгийн сайн мэдэх Энэдхэг-Европ хэлний зүй бичдэг зарчмыг баримтласан хэрэг бөгөөд үүнийг буруутгах аргагүй буй заа. Харин монголчуудын тухайд, бусдын ам санааг дагахаас өөр арга байгаагүй гэж улс төрийн үүднээс тайлбарлаж болох боловч шинжлэх ухааны үүднээс зөвтгөх хэрэг огт биш.

Энд бас нэгэн зүйлийг нэмж тэмдэглэхэд, Энэдхэг-Европ хэлний зүй нь тийн ялгал, тоо, хүйс зэрэг олон асуудлаараа яв явсаар эртний

² Монгол хэлний шинжлэлийн дурсгал бичиг, Хөххот, 1959; Ринчен, Монгол бичгийн хэлний зүй, тэргүүн дэвтэр, удиртхал, Улаанбаатар, 1964. Монгол хэл шинжлэлийн дурсгал, Улаанбаатар, 1997.

Энэдхэгийн Банины "Хэлзүй"-н онол бодролтой нягт холбоотой байдаг³ тул монголын уламжлалт хэлшинжлэлийн зохиол бүтээл дэхи тодорхойлолттой олон зүйл дээр үндсэндээ тохирдог бөлгөө. Иймд, монголын уламжлалт хэл шинжлэлийн ном зохиол хийгээд Энэдхэг-Европ хэлзүйн зарчмыг дагаж зохиосон сүүл үеийн монгол хэлзүйн бүтээлд адил үзэл, дүгнэлт олон тохиолддогийг нарийн мэргэжлийн бус хүн өнгөц хараад, монгол хэлний жинхэнэ онцлог нь ийм л учраас эрт болоод эдүгээгийн олон хэлзүйн номд адилхан тайлбарлажээ гэж эндүүрэн итгэхэд хүрч, тэр нь улмаар үнэмшил хэвшил болсон тал ч бий.

2. 2. Харьцангуй хожуухан үеэс, тухайлбал ХХ зууны тавин хэдэн оноос эхлэж монгол хэл нь үг бүтэх ёсон, хэлзүйн байгуулал зэрэг олон зүйлээрээ самгард (<Samskrta), төвөд, болон Энэдхэг-Европ овог хэлнээс үлэмжхэн ялгаатай гэдгийг дурдан гаргаж, тэрхүү өвөрмиц ялгаа заагийг илүү анхаарч, монгол хэлний уугуул онцлогийг тодруулах, хуучин тогтсон үзлээс өөрөөр тайлбарлахын эхийг академич Ринчен багштан 1956 онд Мажарт хэлшинжлэлийн докторын зэрэг хамгаалсан, монгол уншигч нарт бүрэн гүйцэд хэвлэгдэн хүртээгүй "Монгол бичигийн хэлний зүй"⁴ гэдэг суурь бүтээлдээ тавьсан хэмээн үзэх бүрэн үндэстэй бөгөөд иймэрхүү үзэл тэр үеэс цөөн хүний явцуу хүрээнд үргэлжилсэн гэж хэлж болно. Учир нь монгол хэлний өвөрмиц онцлогийг тогтсон загвараас өөрөөр тодорхойлох нь тухайн үеийн улс төрийн шалтгаан хийгээд олон нийтийн санаа бодол дахи үхширсэн үзэл, хэвшсэн үнэмшил зэргээс болж төдий л дэмжилгэ олоогүйгээр үл барам зохиогчдыг үүгээр нь их бага аль нэгэн хэмжээгээр өөчлөн дарамтлаж байсантай холбоотой юм.

Эл өгүүлэлд, монгол хэлэн дэхи тийн ялгалтай холбогдох нэр томъёоны хүрээнд, дээр дурдсан санааг аль нэгэн хэмжээгээр тодруулж нутлан үзүүлэхийг зорив. Цаашид ч энэ мэтийн бусад асуудалыг шууд холбогдол бүхий баримт сэлтээр үүнчилэн цувуулж гаргах санаа бий.

Энэ ташрамд дурдахад, олон Улсын Монголч Эрдэмтний хоёрдугаар Их хуралд профессор Чой. Лувсанжав багштан "Монгол хэлний тийн ялгалын тухай" гэдэг илтгэл тавьж хэлэлцүүлсэн бөгөөд үүндээ монгол хэлний тийн ялгалыг илэрхийлэх утга хийгээд үүргийнхи нь үүднээс авч үзээд монгол хэлний тийн ялгалын мөн чанарыг хэрхэн үзүүштэй байна вэ? гэдэг талаар саналаа дэвшүүлсэн бөлгөө⁵. Иймд багшийнхаа тэр өгүүлэлийн үргэжлэл болгож монгол, төвөд, самгард хэлзүй дэхи тийн ялгалыг харьцуулан нэр томъёо, утгын тайлбар болон дэс дараа зэрэг олон зүйлээрээ нэгэн адил болохыг нь тодорхой баримтаар гарган үзүүлж олон нийтэд танилцуулахыг эрмэлзэлээ.

Үүний өмнө 1957 онд Л. Мишиг, 1958 онд Т. Пагва, 1962 онд П. Б. Балданжапов нар монгол уламжлалт хэлшинжлэлийн бүтээл дэхи нэрийн тийн ялгалын тухайд төвөд хэлний тийн ялгалын ангилал тодорхой

³ *The New Encyclopaedia Britannica*, Micropedia, 1985, Vol. X, p. 422.

⁴ Ринчен, *Монгол бичигийн хэлний зүй*, I-IV дэвтэр, Улаанбаатар, 1964- 1967.

⁵ Чой. Лувсанжав, *Монгол хэлний "тийн ялгал"-ын тухай*, - МУИС, Эрдэм шинжилгээний бичиг, N. 41, Улаанбаатар, 1972, 29-38-р тал; Choi. Lubsangjav, *On the case in Mongolian* - Олон Улсын Монголч эрдэмтний II Их хурал, I боть, Улаанбаатар, 1973, 279-281-р тал.

нөлөөлсөн гэдгийг тэмдэглэсэн байдаг⁶ ба 1970 онд профессор Д. Төмөртоогоо *Монгол хэлний шинжлэлд нэрийн тийн ялгалыг ангилсан нь* гэдэг томоохон өгүүлэлдээ баримт түшиглэн авч үзээд:

...тийн ялгал бүрийг тийнхүү тоогоор дугаарлан нэрлэх нь тухайн нэгэн тийн ялгалын нөгөөгөөс ялгагдах гол үндсэн шинжийг хэт бүрхэгдүүлэх талтай байна. Тийм учраас төвд хэл зүйчид тийн ялгалыг тоогоор дугаарлан нэрлэхийн оронд гол үндсэн утгаар нь төлөөлүүлэн нэрлэх зарчим тогтоосон байна.

Хуучин монгол хэл зүйчид дээрх хоёр зарчмын аль нэгийг тэр хэвээр нь хуулбарлан дуурайсангүй, харин гол утгаар нь төлөөлөн нэрлэх, тоогоор дугаарлан нэрлэх хоёр зарчмыг бүтээлчээр хослуулан ... нэрлэх өвөрмөц зарчим тогтоосон байна. Энэ нь тухайн нэгэн тийн ялгалын нөгөөгөөсөө ялгарах гол утгыг зааж чадахаас гадна мөн уул тийн ялгалын нөхцлөөр илэрч гарах бусад олон салбар утгыг нийтэд нь хамруулан нэрлэж чадах боловсронгуй арга юм...⁷

гэж дүгнэн тэмдэглэжээ. Бид энэ өгүүлэлдээ дээрхи санааг улам гүнзгийрүүлэхийн хажуугаар монгол, төвөд хэлзүйчидээс тийн ялгалыг хоёр зарчимаар нэрлэж ирсэн уламжлалын уг үүслийг нь хайн тодруулах баримтыг аль нэгэн хэмжээгээр гарган үзүүлэхийг давхар эрмэлзсэн болно.

Үүнд: монгол хэлзүйн гол хэрэглэгдэхүүн болгож “*Зүрхний толтын тайлбар үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч огторгуйн маани*” хэмээх зохиолыг сонгож авав. Учир нь, энэ ном нэгд, монгол хэлзүйн харьцангуй олон асуудлыг хамран багтаасанаас гадна уг эхээрээ олдсон энэ хир хамгийн эртний бүтээлд тооцогдож буй, хоёрт, XIII зууны үед Чойжи-одсэрийн зохиосон “*Зүрхний толт*”-ын тайлбар болгож Найралт Төвийн хаанчлал (1723-1736)-ын үед зохиогдсон, гуравт, хэлшинжлэлийн сүүлд гарсан хэд хэдэн гол зохиолын үндэс болсон тул ийнхүү онцлож үзсэн бөлгөө. Харин зохиогч Данзандагвын хувьд, судлагчид санал нэгдээгүй, нэгэн зарим нь Өвөр монголын Шилийн гол аймгийн зүүн Үзэмчин хошууны Ламын хүрээнд хувилгаан лам байсан монгол хүн гэж үзэж байна⁸. Сүүлийн үед зарим хүний судлагаанд төвөд хүн байсан хэмээжүүхүй⁹.

Төвөд хэлний тухайд Оросын нэрт төвөдөч-монголч Ю.Н.Рерих профессорын “*Төвөд хэл*” гэдэг хэлзүйн бүтээл нь төвөд хэлзүйг бичдэг тогтсон уламжлалаар зохиогдсон тул гол хэрэглэгдэхүүн болгов¹⁰.

⁶ Л. Мишиг, *Монгол хэлний тусгагдахуун ба байц*, Улаанбаатар, 1957, 9-р тал; Т. Пагва, *Монголын хэлзүйч эрдэмтэн Сумадираднаагийн бүтээлийн товч тойм*, Улаанбаатар, 1958, 8, 10-р тал; П. Б. Балданжапов, *Монгольское грамматическое сочинение XVIII века*, Улан-Удэ, 1962, стр. 94.

⁷ Д. Төмөртоогоо, *Монгол хэлний шинжлэлд нэрийн тийн ялгалыг ангилсан нь*, - *Studia Linguae et Litterarum*, Tomus. VIII, Fasc. 8, Улаанбаатар, 1970, 314 (301- 314).

⁸ *Монгол хэл шинжлэлийн дурсгал бичиг*, Хөххот, 1983; *Монгол хэл шинжлэлийн дурсгал*, хянан тохиолдуулсан Ц.Өнөрбаян, Улаанбаатар, 1997, 18-р тал.

⁹ *Монгол хэлний судлал*, Хөххот, 1990; *Монгол хэл шинжлэлийн дурсгал*, хянан тохиолдуулсан Ц.Өнөрбаян, Улаанбаатар, 1997, 18-р тал.

¹⁰ Ю.Н.Рерих, *Тибетский язык*, Москва, 1961, стр. 58-61.

Самгард хэлний хувьд, Баруун Европ дахинаа гарсан нэлээд хэдэн номыг үзсэн бөгөөд цөм самгард хэлзүйг зохиодог уламжлалт зарчмыг баримтласан байх ба тийн ялгалын дугаар, дэс дараа, сүүлд оноосон нэр зэрэг нь цөм ижил тул 100 гаруй жилийн өмнө хэвлэгдсэн Жюле Опперт профессорын “Самгард хэлний зүй” гэдэг номыг сонгож авсан бэлгээ¹¹.

Монгол хэлний “тийн ялгал” гэдэг нэр томъёоны гарлыг хөөн үзвэл төвөд хэлний *nam-dbye* гэдэг нэрийн үгчилсэн орчуулга бөгөөд цааш нь нягтлал тэрхүү *nam-dbye* гэдэг нь угтаа самгард хэлний *vibhaktiḥ* гэдэг үгийн махачилсан орчуулга ажээ.

Ингээд тийн ялгалын дэс дугаар (ду:), нэр (нэ:), гол утга (ут:), нөхцөл (нө:)-ийг монгол, төвөд, самгард хэлзүйн дурдсан бүтээлүүдэд хэрхэн тодорхойлсоныг товч боловч харьцуулахад олон зүйл бэлхэнээ тодорхой болж ирнэ.

Монгол, төвөд, самгард хэлний тийн ялгалыг харьцуулсан хүснэгт

“Зүрхний толтын тайлбар”	“Төвөд хэл”	“Самгард хэлний зүй”
ду: Анх тийн ялгал нэ: ∅ ут: чанар төдийг заана нө: ∅	<i>nam-dbye dan-po</i> “анх т. я.” ∅ нэрийн мөн чанарыг үзүүлнэ ∅	<i>Prathama vibhaktiḥ</i> “1-р т.я.” (Nominatif - нэрлэхийн т.я.) Karta “factor” - үйлийн эзэнийг заана
ду: Хоёдугаар тийн ялгал нэ: ∅ ут: явах хүрэх үйл үзүүлнэ нө: -a/-e, -dur/-tur, -dür/-tür	<i>nam-dbye gnis-pa</i> “2-р т.я.” ∅ зорилго, чиглэлийг үзүүлнэ (сул үг) <i>la, su, r, ru, du, tu, na</i>	<i>Dvitiya vibhaktiḥ</i> “2-р т.я.” (Accusatif - заахын т.я.) Karma “factum” - үйлд өртөгчийг заана
ду: Гутгаар тийн ялгал нэ: ∅ ут: үйлдэгчийг үзүүлнэ нө: -bar/-ber, -iyar/-iyer	<i>nam-dbye gsum-pa</i> “3-р т.я.” ∅ багаж, шалтгааныг үзүүлнэ (сул үг) <i>s, gis, kyis, gyis</i>	<i>Tṛtiya vibhaktiḥ</i> “3-р т.я.” (Instrumental - үйлдэхийн т.я.) Karanam- шалтгааныг заана
ду: Дөтгөөр тийн ялгал нэ: ∅ ут: хэргийг үзүүлнэ нө: -dur/-tur, -dür/-tür	<i>nam-dbye bzi-pa</i> “4-р т.я.” ∅ өгөх, үйлийн зорилгыг үзүүлнэ (сул үг) <i>la, su, r, ru, du, tu</i>	<i>Caturthi vibhaktiḥ</i> “4-р т.я.” (Datif - өгөхийн т.я.) Sampradanam - өгөлгийг заана
ду: Тавдугаар тийн ялгал нэ: ∅ ут: гарах угыг үзүүлнэ нө: -aṣa/-eṣe	<i>nam-dbye ina-pa</i> “5-р т.я.” ∅ уг гарлыг үзүүлнэ (сул үг) <i>nas, las</i>	<i>Pancami vibhaktiḥ</i> “5-р т.я.” (Ablatif - гарахын т.я.) Apadanam - гарлыг заана
ду: Зургадугаар тийн ялгал нэ: ∅ ут: утгыг холбож үзүүлнэ нө: -u/-ü, -un/- ün, -yin	<i>nam-dbye drug-pa</i> “6-р т.я.” ∅ холбоо хамаарлыг үзүүлнэ (сул үг) <i>i, gi, kyi, gyi</i>	<i>Shashthi vibhaktiḥ</i> “6-р т.я.” (Genetif - харьяалахын т.я.) Sambandhas - холбоог заана
ду: Долдугаар тийн ялгал нэ: ∅ ут: буй орныг үзүүлнэ нө: -a/-e, -dur/-tur, -dür/-tür	<i>nam-dbye bdun-pa</i> “7-р т.я.” ∅ үйлийн цаг, орон үзүүлнэ (сул үг) <i>la, su, r, ru, du, tu</i>	<i>Saptami vibhaktiḥ</i> “7-р т.я.” (Locatif - оршихын т.я.) Adhikaranam - орныг заана

¹¹ Jules Oppert, *Grammaire sanscrite*, Paris, 1864, p. 30.

ду: Ø	(<i>rnam-dbye brgyad-pa</i> "8-р тийн ялгал")	Ø
нэ: Дуудахуйн тийн ялгал ут: (дуудах дууг үзүүлнэ) нэ: Аяа! Оо! ...	Дуудахын тийн ялгал хандан дуудахыг үзүүлнэ (сул үг) <i>kye, kwa-ye</i>	Vocatif - дуудахын т.я. Sambodhanam - дуудах

Энэхүү харьцуулсан хүснэгтээс, дурдсан гурван хэлний тийн ялгалд холбогдох нэр томъёоны гарал үүсэл, нөлөө тусгал, түүний зам чийрийн талаар доорх хэдэн дүгнэлтийг хийж болно. Үүнд:

1. Дээрхи баримтаас үзвэл, дуудахын тийн ялгалаас бусад нь анх тусхай тогтсон нэргүй, зөвхөн 1 - 7 гэсэн дугаартай байсан ажээ. Самгард хэлний зүйд латин гаралтай нэр байгаа нь сүүлд герег-романы уламжлал (The Greco-Roman tradition)-аар оноон өгсөн нь тодорхой тул бид хаалтанд хийсэн болно. Харин дуудахын тийн ялгалын тухайд ганцаараа нэртэй тул дугаарлалгүй орхисон байдал нь дурдсан гурван хэлнээ адил байсан бололтой. Ю.Н.Рерих профессор номдоо дуудахын тийн ялгалыг "8-р тийн ялгал" гэсэн нь бусад тийн ялгалын жишигээр сэргээн дугаарласан гэж үзсэн учир мөн хаалтанд хийлээ.

Иймээс долоон тийн ялгалыг дугаарласан болоод дуудахын тийн ялгалыг эс дугаарласан байдал цөм адилхан байгаа нь хуулбарын чанартай гэж итгэлтэй хэлж болно.

2. Тийн ялгал тус бүрийн илэрхийлэх утга буюу үүргийг тайлбарласан байдал нь монгол, төвөд, самгард хэлзүйд дам дам орчуулсан байдалтай буюу адилхан байна.

3. Тийн ялгалуудын нөхцөлийн жагсаасан байдлыг харахад бас нэгэн сонин зүйл ажиглагдаж байна. Үүнд: төвөд хэлний 2, 4, 7-дугаар тийн ялгалын утгыг *-la, -su, -r, -ru, -du, -tu, (-na)* гэдэг сул үгээр гурвууланд нь адилхан илэрхийлдэг бөгөөд монгол хэлний тухайд ч тэдгээр гурван тийн ялгалын нөхцөл нь цөм адилхан, *-dur/-tur, -dür/-tür, (-a/-e)* нөхцөлтэй байгааг дээрхи хүснэгтээс шууд харж болно. Үүний учрыг нарийвчлан үзвэл, төвөд хэлнээс монгол руу ном зохиол орчуулахад төвөд хэлний дээрхи нөхцөлийг монгол хэлний дурдсан нөхцөлөөр оноон орчуулдаг уламжлалтай яг тохирдог бөлгөө.

Үүнээс үүдэж "Зүрхний толтын тайлбар"-т, төвөд хэлний тухайн тийн ялгалын утга илэрхийлдэг сул үг¹²-ийг монгол руу ямар нөхцөлөөр хэрхэн орчуулдаг уламжлалыг гол болгосноос биш, монгол хэлний "тийн ялгал" гэдэг зүйлийн өөрийнхи нь онцлог, мөн чанарыг бараг анхаарсангүй гэж хэлж болно. Тийм ч учраас орчин цагийн монгол хэлний зүйд уламжлал болсон *-i, -yi* нөхцөл бүхий Заахын тийн ялгал, *-luγ-a/-lüge* нөхцөлтэй Хамтрахын тийн ялгал бүрмөсөн орхигдсон ажээ. Учир нь, монгол хэлний энэ хоёр тийн ялгалын утга илэрхийлдэг нөхцөлтэй дүйдэг төвөд "үг" нь төвөд хэлэндээ тийн ялгалд хамаардаггүй болохоор Заах, Хамтрахын тийн ялгалыг тийн ялгал гэж тооцоогүй

¹² Бид энд төвөд хэлний тухайд, тийн ялгалын "нөхцөл"-ийг сул үг хэмээсэн нь төвөд хэлний өөрийнхи нь онцлогтой шууд холбоотой бөгөөд энэ тухай хойно тодорхой дурдах болно.

бололтой. Тэгээд ч “Зүрхний толтын тайлбар”-т *-i, -yi* нөхцөлийг “орхиц”, *-luγ-a/-lüge* нөхцөлийг “хураах үг” гэж тусгайлан нэрлэсэн байна.

4. Төвөд хэлний судлалаар гарсан сүүлийн үеийн эрдэм шинжилгээний нэг бус бүтээлээс үзвэл, төвөд хэлзүйн уламжлалд олон асуудлыг самгард хэлний үүднээс тайлбарласан гэдгийг судлагчид хүлээн зөвшөөрөх болжээ. Жишээлбэл: Ю.Н.Рерих профессор

“...Төвөд хэлний зүй дэхи нэрийн тийн ялгалын тогтолцоо нь самгард хэлзүйн ном зохиолоос орсон юм...”

гэж тэмдэглэжээ¹³.

Мөн оросын төвөдөч Ю.М.Парфионович 1970 онд

“...Төвөд хэлний нэр үгэнд хэлзүйн тийн ялгалын ай гэж байхгүй. Самгард хэлний уламжлалыг баримтласан үндэснийхи нь хэлзүй болоод Энэдхэг-Европ хэлний тогтолцоогоор зохиосон төвөд хэлний зүйн номд төвөд хэлийг 6-8 тийн ялгалтай гэж үздэг боловч түүнийг зөвшөөрөх аргагүй юм. Учир нь тийн ялгал гэдэг нь өөрийн тусхай нөхцөлтэй байдаг бол төвөд хэлэнд тийм нөхцөл байдаггүй, харин тийн ялгалын харьцааг туслах бүтээвэр (службные морфемы)-ээр илэрхийлдэг. Тэрхүү туслах бүтээвэр нь үгзүйн төвшинд биш, өгүүлбэрзүйн төвшинд, тухайн үгийг нэр үгийнхи нь хувьд бус, өгүүлбэрийн гишүүний нь хувьд л нэр үгтэй холбогдож байгаа хэрэг юм...”

гэж онцлон дурдсан байдаг¹⁴. Энэ ташрамд тэмдэглэхэд Ю.Н.Парфионовичийн “туслах бүтээвэр” (служебные морфемы) гэснийг Ю.Н.Рерих профессор “сул үг” (частицы) гэж нэрлэсэн нь санамсаргүй хэрэг биш бөлгөө. Төвөд хэлний тэдгээр “сул үг” нь зөвхөн нэр төдийгүй бас үйл үгтэй холбогдож болдогоос гадна заримдаа холбоосын үүргээр ч ордог тохиолдол буй билээ. Бас нэмж дурдахад, япон хэлнээ тийн ялгалын тусгай нөхцөл гэж байдаггүй, мөн л туслах үгээр уг харьцааг илэрхийлдэг хэмээн үздэг байна¹⁵.

Энэ бүхнээс үндэслээд монгол хэлний тийн ялгал болоод түүнтэй холбогдох нэр томъёоны талаар урьдчилсан ямар дүгнэлт хийж болох вэ? гэдэг асуулт гарч байна. Үүнд, дараахи хэдэн саналыг толилуулая.

- Монгол хэлшинжлэлийн уламжлалт зохиол дахи “тийн ялгал” гэдэг ойлголт болоод түүнд холбогдох нэр томъёо нь угтаа төвөд хэлээр дамжин орж ирсэн Самгард хэлзүйгээс гаралтай байна.

¹³ Ю.Н.Рерих, *Тибетский язык*, Москва, 1961, стр. 58.

¹⁴ Ю.М.Парфионович, *Тибетский письменный язык*, Москва, 1970, стр. 71.

¹⁵ Хас-эрдэнэ, Ман Ли-ян, *Монгол япон хэлний тийн ялгалын харьцуулал*, - (Соёл эрдэнэ дээд сургууль) *Эрдэм шинжилгээний бичиг*, N.1, Улаанбаатар, 1997, 4-23-р тал

- Орчин цагийн монгол хэлзүйн бүтээл дэхи "тийн ялгал" гэдэг ойлголт нь монголын уламжлалт хэлшинжлэлийн бүтээлд буй "тийн ялгал" гэдэг ухагдахууны шууд үргэлжлэл бөгөөд шинэ нөхцөлд Энэдхэг-Европ хэлзүйн уламжлалыг үлэмжхэн тусгасан гэж үзэж болно. Үүнд, тийн ялгалын нэр, дэс дараалал болоод түрүүн байгаагүй Заах, Хамтрахын тийн ялгалыг нэмж оруулсан зэргийг дурдаж болно.

Дээр өгүүлсэн зүйл бол монгол хэлэнд "тийн ялгал" гэдэг хэлзүйн ай онолын үүднээс байна, байхгүй гэдгийг шийдэж буй явдал биш бөгөөд түүхэн баримтыг хөөн үзвэл ийм байна гэдгийг энэ удаа толилуулж байгаа хэрэг юм. Үүнтэй холбогдуулан дурдахад "Зүрхний толтын тайлбар"-ын төгсгөлийн үгэнд "...Чойжи-одсэрийн зохиосон "Зүрхний толт"-ын тайлбар хийгээд Монголд үгүй тийн ялгал тэргүүтнийг тодорхой гаргаваас зохистой хэмээсэн ёсоор Сажа бандида хийгээд Пагва ламын зохиол хийгээд Чойжи-одсэрийн зарлигт-баар шүтэж ..." гэсэн үг байдаг нь бидний сонирхолыг багагүй татаж байна. Иймд, үүнээс өмнөхи монгол хэлзүйн бичгүүдэд "тийн ялгал"-ын талаар дурдаж байгаагүй бололтой гэж үзэж бүрэн болмоор байна. Нэр дурдсан хүмүүсийн дотор нэлээд хэд нь төвөд хүн байгааг мартаж болохгүй буй заа. Бас "Зүрхний толтын тайлбар"-ыг уншихад хэл найруулга нь Сонгодог монгол бичгийн хэлэнд ихээхэн ойр бөгөөд төвөд хэлний найруулгын нөлөө үлэмжхэн буйг саяхи эшлэл хэдийгээр бага боловч бэлхэнээ харуулж өгнө гэж бодож байна. Түүнээс гадна Чойжи-одсэр, Гунгаа-одсэр нарын "Зүрхэний толт" зохиолд дурдаагүй л бол, бүх зүйлийг "хор мэт тэвчигдэхүй" гэж онцлон тэмдэглээд хэрэглэхийг хориглосон байдаг. Жишээлбэл: одоогийн "ч" (Мо. сi ~ cu) хэмээх сул үгийг ингэж үзжээ.

Хэлзүйн хувьд аль нэг хэлний жишиг, загвараар нөгөө нэг хэлийг үзэх явдал зөвхөн монгол хэлний тухайд ч бус, бусад хэлний хувьд ч байсаар, тэр нь аажмаар засагдсаар ирдэг зүйл билээ. Ялангуяа шашин суртлын учир холбогдлоор тодорхой нэг бүс нутагт хүчтэй болсон судар номын хэл бусад хэлнүүдэдээ үлэмжхэн нөлөөтэй байсаар иржээ. Тухайлбал: Азийн олон орны хувьд ийм нөлөөтэй хэл гэвэл хятад хэл бичгийг ч дурдаж болно. Бас Төв Азид Бурханы шашны учир холбогдлоор самгард хэл төвөд хэлний зүйд, төвөд хэл монгол хэлний зүйд дам нөлөөлсөн шиг Дундад зууны үед Европ дахинд ном судрын хэл болж байсан латин хэл нь төрөл биш бусад хэлний зүйд хүчтэй нөлөөлж байсан баримт буй. Ийм байдлыг нэрт хэлзүйч Сэйс "Хэлзүй" гэдэг бүтээлдээ "...Латин хэлний зүйд байдаг өвөрмиц харьцааг англи хэлэнд буй гэж олохыг оролдсон нь харин ч аягүй алдаатай юм болж, англи хэлний үг найралгыг огт мэдэхгүй байдалд хүргэсэн билээ..." гэж дурдсан байдаг байна¹⁶. Мөн орчин үеийн байршиц хэл шинжлэлийг үндэслэсэн Х. А. Глисон (H. A. Gleason) гол бүтээлдээ:

"... Олон олон үе, латин хэлний зүйг үлгэр хэв болгосоор ирлээ. Голцуухан ижил дасал болчихсон латин хэлний үгсийн аймгийг, бусад хэлнээ байсан ч байгаагүй ч, байгаа гэж үзэж сурчихжээ. Чингээд латин хэлний бүх хувилгааны тогтчихсон хэв хайрцагт

¹⁶ Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, тэргүүн дэвтэр (Удиртхал дэвтэр), Улаанбаатар, 1964, 21-р тал.

(бусад хэлийг) таарсан ч бай таараагүй ч бай тааруулдаг болжээ. Тун саяхан болтол, англи америкийн сургуулийн хүүхэд багачууд, латин хэлний хэвд тааруулсан, дор дурдах тийн ялгалын хувилгааг албан хүчээр сургаж байлаа. Үүнд:

Ганц тоот хэлбэр нь: нэрлэх	the boy	puer
Харъяалах	of the boy	pueri
өх	to the boy	puero
заах	the boy	puerum
гарах	from the boy	puero
дуудах	O boy!	Puer

Олон тоот хэлбэр нь ч мөн энэ жишлэнгээр хувилна.

Иймэрхүү хэлзүйн үр хаялга нь юу байна вэ? гэвэл, хэлзүй гэдэг чинь үе уламжлан сургаад заншчихсандаа болохоос биш, утгагүй хэв юм байна шүү дээ гэх санааг сурагч окуутанд төрүүлдэг юм...

Энэ бол ёстой инээдэмтэй хэрэг. Хэл гэдэг зүйл бол цэгцэрсэн бүтэц бөлгөө. Хэлийг судлана гэдэг нь тэрхүү бүтэцийг л судлана гэсэн үг. Аливаа бүтэцийг ингэж судлаж гэмээ нь хэлзүй болдог юм...

Англи хэлний зүйг латин хэлний хэвд тааруулан хүлэж байсан хүлээс алдран саарч байгаа нь мань англи хэлний мэдэлгийг түргэнээ ахиулахын нэгэн хавтай үеийг эхлүүллээ..." гэж бичсэн байдаг¹⁷.

Солонгос хэлний тухайд, хоёр янзын хөг буй гэж 1444 онд шинээр зохиосон Hunmin chōng'ūm хэмээх үндэснийхээ цагаан толгойт бичигт нэгэн хэсэгтээ тусгайлан тэмдэглэж байсан нь даруй хятад хэлбичгийн нөлөө байсан бөлгөө¹⁸. Харьцангуй сүүл үеийн баримт гэхэд социалист систем гэж байх үест орос хэл бичиг, Зөвлөлтийн хэлшинжлэлийн онол ихээхэн нөлөөтэй байсныг бид мэднэ зээ. Энэ мэтээр авад дуусахгүй олон жишээг жагсаан дурдаж болно.

Энэ ташрамд нэмэж хэлэхэд "Сонгодог монгол бичгийн хэл" гэдэг нь Эртний Энэдхэг, Төвөдөөс улбаатай дорно дахины уламжлал бүхий асар олон бүтээл туурвилыг монголчлосны хувьд "сонгодог" зүйл мөн боловч монгол хэлний зүй хийгээд монгол хэлний найруулгын үүднээс үзвэл, төвөд номын хэлний өнгө аясыг үлэмжхэн тусгасанаараа чухамхүү "сонгодог" гэж хэлэхэд учир дутагдалтай бөгөөд энэ тухай "Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүний судлагааны тойм" гэдэг өгүүлэлдээ зарим жишээ баримттай, арай тодорхой дурдахыг оролдсон

¹⁷ Н. А. Gleason, *An Introduction to Descriptive Linguistics*, New York, 1955, pp. 125-126; Г. А. Глисон, *Введение в дескриптивную лингвистику*, Москва, 1959, стр. 182-183; Н. А. Gleason, *Introduction à la Linguistique*, Paris, 1969, pp. 102-103.

¹⁸ Ц. Шагдарсүрэн, *Монгол солонгос бичиг үсгийн харилцаа холбооны асуудалд*, - *Mongolian Studies* (The Korean Association for Mongol Studies), N. 4 (1996), Seoul, 1997, p. 183; Ts. Shagdarsuren, *A Study of Relation between the Korean and Mongolian Scripts*, Research paper for the Korea Foundation, 1998, 31 p.; Chong Yon Cha'n, *A Study on the Korean tones in 15th century*. - *Kugo Yon'gu* N. 8, Seoul, 1960; Lee Sang Oak, *On the Origin of Middle Korean Tone*, - *Language Research*, Vol. 15, N.1, Seoul, 1979.

учир энд дахин нурших явдалгүй гэж үзлээ. Үүний дээр яг энэ талаар тусхай өгүлэл бичих санаа буй.

Мөн тэр үед эртний Энэдхэгийн яруу найраг, уран зохиолын (Kavyadarśa хэмээх) “*Зохиост аялгуун*”-ы онол төвөдөөр дамжин монголын яруу найргийн зохиолд үлэмжхэн нөлөөлснийг нэмж хэлэлгүй орхиж болохгүй байх аа. Учир нь, Монголын олон үеийн бичгийн хүмүүс маань энэдхэгийн номын хэлээр Данди, монголоор Бэрээт хэмээгчийн тухайн үедээ үлэмжхэн нэрд гарч алдаршсаар ирсэн энэ онолыг монгол яруу найраг хийгээд уран зохиолын ухаанд хэрэглэн дэлгэрүүлэхийн сац **монгол уламжлалд ойртуулж шинэчлэл хийж улмаар уг онолыг улам** нарийсган хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан зэрэг нь яриангүй гавъяатай хэрэг мөн боловч олон нийтийн дунд монгол яруу найрагийн уламжлалт уугуул өвөрмиц онцлогийг харьцангуй бага анхаарах шалтгаан болсон байж болзошгүй гэж үүнийг бичигч молхи толхи хүмүүнд эрхгүй санагддаг бөлгөө.

Ер нь зөвхөн монгол хэлний тухайд төдийгүй судлагдахуун болж буй аливаа хэл хийгээд түүнлүгээ төрөл бусад хэлний уугуул онцлогийг жинхэнэ байдлаар гаргах нь мэргэжлийн хэлшинжлэлч хүний нэг гол үүрэг мөн буй заа. Ийм болохоор бидний хувьд зөвхөн монгол төдийгүй Алтай овогийн бусад хэлний судлалд гарч буй шинэ сэрэг үзэл, таамаглалыг анхаарахгүй байхын аргагүй юм. Зарим нэг баримтыг дурдахад түрэг зүгийн хэлний тухайд олон тооны ай нь Энэдхэг Европ хэлнийхиэс их л өвөрмиц байдалтай тухай¹⁹; мөн хэлбэрсудлал буюу үгзүйн үүднээс түрэг хэлнүүдэд тэмдэг нэр гэж байна уу? үгүй юү? (зарим) тийн ялгал гэж байна уу? үгүй юү? гэх зэрэг нэлээд асуудлаар нэг бус эрдэмтэн эргэлзэн тэмдэглэсээр байгаа билээ²⁰.

Шинжлэх ухааны хувьд нэгэнт хэвшчихсэн ойлголтын талаархи аливаа шинэ зүйл гарч ирэхдээ амаргүй замыг туулдаг бөгөөд энэ тухай нэгэн наргиа яриа байдагийг хэлэхэд: эхний үед бараг л цөмөөрөө “*ийм юм байж яаж болох юм бэ?*” гээд шогшрон толгой сэгсэрдэг; дараа нь “*энэ чинь нэг юм хэлэх гээд байна шүү?!*” гээд нүдээ жийхайлгаж бодолхийлэн толгой дохиж эхлэдэг; сүүлдээ “*ийм юмыг мэддэггүй хэн байсан юм бэ?*” гээд бүр тоохоо больдог гэлцэнэм.

¹⁹ Тэмдэглэх нь: Олон Улсын Монголч эрдэмтний хоёрдугаар Их хуралд академич Ринчен багштан монгол хэлний тооны айн талаар тусхай илтгэл тавьсан бөгөөд түүнд дэвшүүлсэн санааг сүүлийн үеийн эрдэмтдийн холбогдох судлагаа улам бүр тодосгон батлан өгсөөр байна. {Y. Rinchen, *Grammatical category of number in Mongolian*, - Олон Улсын Монголч эрдэмтний II Их хурал, II боть, Улаанбаатар, 1973, 74-76-р тал.}

²⁰ Fred W. Housholder and Sol Saporta, *Problems in Lexicography*, Indiana University, Bloomington, 1967.